

# Дэлхийн залбирлын өдөр 2025

**Магтаал**—Бурхан бол ялалт: Эсрэг тал юм уу дайснаа ялсан давуулан дийлсэн; ялалт байгуулагч; хамгаалагч; аврагч; ялалт байгуулан баяр ёслолтойгоор хотдоо ирэгч; эрхэндээ оруулагч.

**1Шастир 29:11** Өө, ЭЗЭН минь, тэнгэрт болоод газар дээрх бүх юмс Таных учир агуу сүр, хүч чадал, яруу алдар, ялалт, цог жавхлан Таных билээ. Өө, ЭЗЭН минь, Та, бүхний дээр эрхэм дээд тэргүүн тул хаанчлал Таных билээ.

**Дуулал 98:1** ЭЗЭНд шинэ дууг дуулагтун, учир нь Тэрээр гайхамшигтай зүйлсийг үйлдсэн Түүний баруун гар ба Түүний ариун мутар Түүнд авралыг гүйцэтгэсэн.

**Сургаалт Үгс 21:31** Хүлэг морьдыг тулааны өдөрт бэлддэг ч Ялалт ЭЗЭНийх болой.

**1Коринт 15:57-58** ... Харин Эзэн Есүс Христээр маань бидэнд ялалт өгдөг Бурханд талархал нь байх болтугай. Тиймээс хайрт ах дүү нар минь, та нарын зүдэл зүтгэл Эзэн дотор хоосон биш гэдгийг мэдэж, тууштай байж, гүйвж дайвалгүй, Эзэний үйл хэргээр үргэлж бялхаж бай.

**Гэмшил**—1 Иохан 1:9 Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ.

**Талархал**—Дуулал 20:5 Бид ялалтад чинь баярлан дуулж, Бурханыхаа нэрээр бид тугаа мандуулах болно. ЭЗЭН бүх гүйлтыг чинь биелүүлэх болтугай!

## Зуучлан залбирал—

**Хүүхдүүд:** \_\_\_\_\_ ын итгэл хүмүүний мэргэн ухаанд бус, харин Бурханы хүчинд байх болтугай.

**1Коринт 2:5**

**Үл итгэгчид:** \_\_\_\_\_ өөр хэний ч дотор аврал үгүй бөгөөд бидэнд аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүнд эс өгөгдсөн гэдгийг мэдэх болтугай.

**Үйлс 4:12**

**Багш нар:** \_\_\_\_\_ ын амнаас нь ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулах тустай үг хэлэх болтугай. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлсэл өгнө.

**Ефес 4:29**

**Сургууль:** Та тэнгэрээс сонсон Өөрийн зарц нар болон \_\_\_\_\_ ын нүглийг уучилж, тэдний явбал зохих зөв зүйтэй замыг Та \_\_\_\_\_ д зааж өгөх болтугай.

**1Хаад 8:36a**

**ЭХЗ:** Бурхан алдар дахь баялгаараа Христ Есүс дотор ЭХЗ-ыг хэрэгтэй бүхнээр хангах болтугай.

**Филиппой 4:19**

**Ерөөлийн залбирал:** Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай. **2Коринт 13:14**

